



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/68

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалт, аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлэл, Ханх сумын Засаг дарга, иргэд, байгууллагуудын хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Мөсөн замын тээвэрлэлтийг хориглох тухай" А/30 дугаар захирамжийн 1 дэх заалтад "...2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс" гэснийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс гэж өөрчилсүгэй.

2. Мөсөн дээр тогтмол хэмжилт хийж, аюултай хэсэгт тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэх, авто тээврийн хэрэгслээр шөнө, оройн цагаар мөсөн дээгүүр тээвэрлэлт гүйцэтгүүлэхгүй байхад анхаарч хөдөлгөөнт хяналт шалгалтыг зохион байгуулах замаар болзошгүй ослоос урьдчилан сэргийлж ажиллахыг сумдын Засаг дарга, тосгоны захирагч нар, мэргэжлийн байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

